



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/525

Номгон


Газар эзэмших эрхийн гэрчилгээт
дуудлага худалдаа зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "г" дэх заалт Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 1 дүгээр бүлгийн 1.2 дахь хэсэг, 5 дугаар бүлгийн 5.1.2 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 116 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Баянхонгор сумын Дуурсах 3-р багийн нутагт "Хонгор 1000" орон сууцны хороололд тус бүр 600м² талбай бүхий 2 газрыг 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалтаар хавсралтад заасны дагуу Газар эзэмших эрхийн гэрчилгээт дуудлага худалдааг зарласугай.

2. Дуудлага худалдааг 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 09 дугаар сарын
18-ны өдрийн А/525 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭТ ДУУДЛАГА
ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН
ЖАГСААЛТ

№	Баг	Байршил	Зориулалт	Талбайн хэмжээ /м2/	Анхны үнэ	Дуудлага худалдаа Зохион байгуулагдах он.сар.өдөр
1	Дуурсах 3-р баг	"Хонгор-1000" орон сууцны хороолол, Хийморь-1 гудамж, 125 тоот	5-8 давхар нийтийн орон сууц	600 м ²	4.500.000	2021.09.23
2	Дуурсах 3-р баг	"Хонгор-1000" орон сууцны хороолол, Хийморь-1 гудамж, 129 тоот	5-8 давхар нийтийн орон сууц	600 м ²	4.500.000	2021.09.23

-----oO-----